



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Өргөн сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДГА-2022/52/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Сайншанд 2022 он	<table><tr><td>Тэргүүлэх аудитор:</td><td>Т.Ган-Өлзий</td></tr><tr><td>Утас: 70522734</td><td>Цахим хаяг: gan-ulziit@audit.gov.mn</td></tr><tr><td>Аудитын менежер:</td><td>У.Оюунтүлхүүр</td></tr><tr><td>Утас: 70523020</td><td>Цахим хаяг: oyuntulkhuur.u@audit.gov.mn</td></tr><tr><td>Багийн ахлагч аудитор:</td><td>Ш.Сувдаа</td></tr><tr><td></td><td>Цахим хаяг: smaudit97@gmail.com</td></tr></table>	Тэргүүлэх аудитор:	Т.Ган-Өлзий	Утас: 70522734	Цахим хаяг: gan-ulziit@audit.gov.mn	Аудитын менежер:	У.Оюунтүлхүүр	Утас: 70523020	Цахим хаяг: oyuntulkhuur.u@audit.gov.mn	Багийн ахлагч аудитор:	Ш.Сувдаа		Цахим хаяг: smaudit97@gmail.com
Тэргүүлэх аудитор:	Т.Ган-Өлзий												
Утас: 70522734	Цахим хаяг: gan-ulziit@audit.gov.mn												
Аудитын менежер:	У.Оюунтүлхүүр												
Утас: 70523020	Цахим хаяг: oyuntulkhuur.u@audit.gov.mn												
Багийн ахлагч аудитор:	Ш.Сувдаа												
	Цахим хаяг: smaudit97@gmail.com												

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу



**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Орон нутгийн өмчийн III байр, Залуучууд гудамж,
3 дугаар баг, Сайншанд сум, Дорноговь аймаг, 44103,

Утас: (705) 2-27-34

Бүх сайт: domogovi@audit.gov.mn

2022.02.25 № 16/264

танай _____-ны № _____-т

ӨРГӨН СУМЫН ЭРҮҮЛ
МЭНДИЙН ТӨВИЙН ЭРХЛЭГЧ
С.АДЪЯАСҮРЭН ТАНАА

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Өргөн сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Өргөн сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Т.ГАН-ӨЛЗИЙ

This PC: D/2022 onii ajil/A4 toot

010020199

Нэг. Санхүүгийн ба төсвийн гүйцэтгэлийн тайлангийн гол үзүүлэлтүүд

		/сая төгрөгөөр/	
	Үзүүлэлт	2020.12.31	2021.12.31
Санхүүгийн байдлын тайлан			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	54.8	216.6
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	287.3	329.7
	Нийт хөрөнгийн дүн	341.8	546.3
	Нийт өр төлбөрийн дүн	1.5	26.6
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	340.3	519.7
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	341.8	546.4
Санхүүгийн үр дүнгийн тайлан			
	Үйл ажиллагааны орлогын дүн	364.2	810.4
	Үйл ажиллагааны зардлын дүн	372.0	632.0
	Үйл ажиллагааны үр дүн	(7.8)	178.3
	Үйл ажиллагааны бус үр дүн	(95.4)	
	Үйл ажиллагааны нийт үр дүн	(7.9)	(178.3)
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	231.0	231.0
	Тайлант оны үр дүн	6.5	178.0
	Эцсийн үлдэгдэл	348.2	519.7
Мөнгөн гүйлгээний тайлан			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	344.0	452.7
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	339.3	438.4
	Үйл ажиллагааны ЦМГ	4.6	14.2
	Хөрөнгө оруулалтын ЦМГ	4.6	(6.6)
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ	-	-
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	-	7.6
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-
Төсвийн гүйцэтгэлийн тайлан			
	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	361.4	358.0
	Урсгал зардал	361.4	358.0
	Хөрөнгийн зардал	-	-
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	361.4	358.0
	Орон нутгийн төсвөөс санхүүжих	20.9	20.3
	Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	320.2	320.2

Хоёр. Байгууллага, түүний үйл ажиллагаа

Өргөн сумын Эрүүл мэндийн төв нь сумын үйлчлэх хүрээний хүн амд эмнэлгийн анхан шатны болон яаралтай тусламж үйлчилгээ үзүүлэх, нийгмийн эрүүл мэндийн боловсрол олгох зорилго тавин ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

Гурав. Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

1. Аудитын excel файлын данс шинэчлэгдээгүйгээс ctsystem.mn программаас хөрвүүлсэн санхүүгийн тайлан дахь дансдын үлдэгдлүүд буруу илэрхийлэгдэж байна. Тухайлбал зөрүүтэй татагдаж байгаа дансдууд:

Орлого үр дүнгийн тайлан: Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого/Үндсэн хөрөнгө-**120017**

Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого/Бараа материал-**120018**

Мөнгөн гүйлгээний тайлан: Нэмэлт санхүүжилтийн орлого-**131107**

1. Эрүүл мэндийн даатгалын сангийн санхүүжилт дутуу олгогдсоноос ковидын тандалт судалгаа, дархлаажуулалт болон шинжилгээ үйлчилгээний зардалд 103.6 сая төгрөгийн авлага, эм бэлдмэлийн зардалд 26.6 сая төгрөгийн өглөг тус тус үүссэн байна.

Дөрөв. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 149 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

2021 онд нийт 358.0 сая төгрөгийн буюу давхардсан тоогоор 149 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас мэдээллийг бүрэн мэдээлсэн байна.

Төсвийн гүйцэтгэлийн мэдээ, санхүүгийн тайлан, аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт, худалдан авах ажиллагааны мэдээллийг шилэн дансны цахим системд хуулиар тогтоосон хугацаанд, бүрэн байршуулсан байна.

Тав. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татах асуудал гаргаагүй болно.

Зургаа. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 197.5 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс аудитаар алдааг залруулав.

Залруулсан алдаа:

1. Цалин хөлсний зардал 197.5 мянган төгрөгөөр орлого үр дүнгийн тайланд дутуу тусгагдсан байна. Аудитын явцад залруулав.

7.1 Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн мэдээлэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
	НИЙТ								

7.2 Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл:

/сая төгрөгөөр/

№	Төсвийн захирагчийн ангилал	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
A	1	2	3	4	5	6	7	8	9	10	11
1	ТШЗ	1	0.2	1	0.2	-	-				
2	Төсөл, хөтөлбөр										
3	ЗГТС										
4	ТТЗ										
5	ТЕЗ										
	НИЙТ	1	0.2	1	0.2	-	-				